ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

#ЗААВАЛ ХИЙЕ!
Забол чөлөөлье



ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ОСОЛ ГЭМТЭЛ БОЛОН БУСАД ЭРСДЭЛТ НӨХЦӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЦГЭЭЕ !

АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

“ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗА БОЛ ЗААВАЛ ХИЙЕ” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД

Хүүхдийн эрхэд сөргөөр нөлөөлж буй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах нь эцэг эх, асран хамгаалагч, байгууллагын ажилтан, албан хаагч бүрийн хамтын үүрэг, хариуцлага мөн. Иймд Хорооны нийт ажилтан, албан хаагчдад хүүхдийн аюулгүй байдлыг хангах, зам тээврийн болон ахуйн осол гэмтэл, гал түймэр, халтиргаа гулгаа, цахим орчны болон бусад эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

#ЗАДАВАЛ ХИЙЕ!
Зөвлөлье

1 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

1. Хүүхдэд замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй зорчих дадал хэвшлийг тогтмол эзэмшүүлэх
2. Сургууль, цэцэрлэг болон олон нийтийн газарт зорчих үед бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх
3. Автомашинаар зорчих үед хүүхдийн нас, жинд тохирсон хамгаалалтын суудал, хамгаалах бүсийг тогтмол хэрэглэх
4. Дугуй, скүүтер болон бусад хэрэгслээр зорчих үед хамгаалалтын малгай, хамгаалах хэрэгсэл өмсүүлэх
5. Харанхуй болон үзэгдэх орчин хязгаарлагдмал үед гэрэл ойлгогчтой хувцас, хэрэглэл ашиглах
6. Зам хөндлөн гарах болон нийтийн тээврээр зорчих соёлыг хүүхдэд үлгэрлэн төлөвшүүлэх
7. ХХЗХ байрладаг Метромолл бизнес төвийн хажуугаар явахдаа өндөр довжооноос унах эрсдлийг анхааруулах, заавал явган зорчигчийн замаар явах, гарцгүй газраар зам хөндлөн гарахгүй байхыг зөвлөх



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

#ЗАДВАЛ ХИЙЕ!
За бол чөлөөлье

2 АХУЙН ОСОЛ, ГЭМТЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

1. Эм, химийн бодис, угаалгын болон ариутгалын бодисыг хүүхдийн гар хүрэхгүй, түгжээтэй газарт хадгалах
2. Хутга, хайч, цахилгаан хэрэгсэл зэрэг эрсдэлтэй эд зүйлсийг аюулгүй байрлуулах
3. Цонх, тагт, шат зэрэг өндөрлөг хэсэгт хамгаалалтын хаалт, түгжээ суурилуулах
4. Бага насны хүүхдийг гэрт нь ганцааранг нь үлдээхгүй байх
5. Халуун ус, халуун хоол, халааалтын төхөөрөмжөөс үүдэлтэй түлэгдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх
6. Тоглоом, ахуйн хэрэглээний эд зүйлсийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавих



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

#ЗАДАВАЛ ХИЙЕ!
Чөлөөлье

3 ГАЛ ТҮЙМЭР БОЛОН ГАМШГИЙН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

1. Гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл, ил задгай утас, ачаалал ихтэй залгуур ашиглахгүй байх
2. Асаагуур, шүдэнз болон гал үүсгэх хэрэгслийг хүүхдийн гар хүрэхгүй газар хадгалах
3. Гэрээс гарахдаа цахилгаан болон хийн хэрэгслийн аюулгүй байдлыг шалгаж хэвших
4. Гал түймэр, газар хөдлөлт зэрэг онцгой нөхцөлд авах арга хэмжээний талаар хүүхэдтэй ярилцаж, бэлтгэлтэй байх
5. Гэр бүлийн хүрээнд яаралтай үед гарах гарц, цугларах цэгийг урьдчилан тодорхойлох
6. Боломжтой нөхцөлд утаа мэдрэгч, гал унтраах анхан шатны хэрэгсэл ашиглах



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

#ЗАДВАЛ ХИЙЕ!
За бол чөлөөлье

4 ХАЛТИРГАА, ГУЛГАА БОЛОН УЛИРЛЫН ЧАНАРТАЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

1. Өвлийн улиралд хүүхдэд халтирдаггүй ултай гутал өмсгөж хэвшүүлэх
2. Мөс, цас тогтсон газар тоглох, гүйхээс болгоомжлуулах
3. Гол, мөрөн, нуурын нимгэн мөсөн дээр гарахгүй байхыг анхааруулах
4. Хэт халалт, хүйтрэлт, аадар бороо, үер ус зэрэг цаг агаарын эрсдэлийн үед хүүхдийн аюулгүй байдлыг онцгой анхаарах
5. Спорт, аялал, амралтын үйл ажиллагаанд оролцох үед хамгаалах хэрэгсэл ашиглах



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

#ЗАДВАЛ ХИЙЕ!
Зогсоол

5 ЦАХИМ ОРЧНЫ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

1. Хүүхдийн интернэт болон цахим төхөөрөмжийн хэрэглээнд зохистой хяналт тавих
2. Хүүхдийн насанд тохироогүй мэдээлэл, зохисгүй контентоос хамгаалах тохиргоог ашиглах
3. Хувийн мэдээлэл, зураг, байршлаа цахим орчинд бусдад түгээхгүй байх талаар хүүхдэд тогтмол зөвлөгөө өгөх
4. Цахим дарамт, залилан, онлайн гэмт хэргийн эрсдэлийн талаар хүүхдэд ойлголт өгөх
5. Гэр бүлийн хэмжээнд цахим хэрэглээний зохистой цагийн хуваарь мөрдөх



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

#ЗАДВАЛ ХИЙЕ!
За бол чөлөөлье

6 ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ

1. Хүүхдийн үзэл бодлыг сонсож, нас, хөгжлийн онцлогт нь тохируулан оролцоог хангах
2. Хүүхдийг аливаа төрлийн хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтаас ангид орчинд өсгөн хүмүүжүүлэх
3. Хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэнд, хөгжлийг дэмжиж, эерэг хүмүүжлийн арга барилыг хэрэгжүүлэх
4. Хүүхдийн эрх зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх
5. Хүүхдийн өмнө хариуцлагатай зан үйлийг үлгэрлэн харуулж, аюулгүй амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

УРИАЛГА

Хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөгжлийг хангах нь гэр бүл, байгууллага, нийгмийн хамтын оролцоо, хариуцлагаас хамаардаг. Иймд **“Хүүхдийн төлөө За бол Заавал хийе”** үндэсний хөдөлгөөнийг дэмжиж, хүүхэд бүрийг эрсдэлгүй, аюулгүй орчинд өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд хамт олноороо идэвхтэй оролцоцгооё.

